

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11	Шилэн дансны мэдээлэл	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
3.1	Анхан шатны баримтын бүрдэл	11
3.1.1	Илрүүлэлт	11
3.1.2	Эрсдэл.....	11
3.1.3	Өгсөн зөвлөмж.....	11
3.1.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар.....	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	13
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	18
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19
4.6	Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	20
5	Хавсралт	22
5.1	Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.02.25 № 06/215
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ойн судалгаа хөгжлийн төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Ойн судалгаа хөгжлийн төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүнгийн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлангууд болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Ойн судалгаа хөгжлийн төвийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Ойн судалгаа, хөгжлийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Д.Мөнхбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ойн судалгаа, хөгжлийн төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ойн судалгаа, хөгжлийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 28-наас 2018 оны 02 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Ж.Болормаа, Э.Энхбаатар нар хариуцаж хэрэгжүүлэв.

Ойн судалгаа, хөгжлийн төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/10 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Ойн судалгаа, хөгжлийн төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Ойн судалгаа, хөгжлийн төв нь “Ойн талаар төрөөс баримтлах бодлого боловсруулахад шаардлагатай мэдээллийг шинжлэх ухаан, техникийн дэвшилтэд арга технологид тулгуурлан ойн тогтвортой хөгжлийг хангахуйц боловсруулж бүрдүүлэх, ногоон хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд өөрийн чиг үүргийн дагуу оролцох” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 89 тоот тогтоолоор ой хамгаалал, арчилгаа, нөхөн сэргээлт, үржүүлэг, судалгаа, зураг, төсөл, хяналт шинжилгээ хийх үүрэгтэй “Ойн судалгаа, хөгжлийн төв” УТҮГ-ыг байгуулсан.

Ойн судалгаа, хөгжлийн төвийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Ойн судалгаа, хөгжлийн төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Ойн тухай хууль (шинэчилсэн найруулга)
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
- Гол мөрний урсац бүрэлдэх эс, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Ойн судалгаа, хөгжлийн төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Ойн судалгаа, хөгжлийн төв санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolum 3.0” програм хангамж ашигладаг байна.

Ойн судалгаа, хөгжлийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Ойн судалгаа, хөгжлийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод

хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төлөвлөлтийн шатанд сонгосон суурийг өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

Ойн судалгаа, хөгжлийн төвийн 2018 оны нийт зардал 10,961,451.6 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 109,614.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь гэрээт ажлуудын санхүүжилт сүүлийн хагас жилд гарч зардал өссөн нь эрсдэлтэй гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	11,103.1	
2	Төлбөрийн акт тогтоосон	2	50,887.0	
3	Албан шаардлага өгсөн	1	34,896.9	
	Дүн	4	96,887.0	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Гэрээт ажлын гүйцэтгэл

Ойжуулалт, ойн арга хэмжээний гэрээт ажлын гүйцэтгэл хангалтгүй 2 аж ахуйн нэгжийн 13,900.0 мянган төгрөг, гэрээт ажлыг гүйцэтгээгүй 2 аж ахуйн нэгжид 39,351.2 мянган төгрөг нийт 53,251.2 мянган төгрөгийн урьдчилгаа шилжүүлж зардлаар бүртгэсэн байна.

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Гэрээт ажлыг гүйцэтгээгүй 2 аж ахуйн нэгжийн нийт 39,351.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоох

2.8.1.2 Авлагын бүртгэл

Өмнөх оны авлага 2,400.0 мянган төгрөг, гэрээт ажлын үлдэгдэл санхүүжилт 9,135.8 мянган төгрөгийг давхардуулан шилжүүлж нийт 11,535.8 мянган төгрөгийн авлага бүртгэсэн байна.

Энэ нь үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Зориулалтын бус зарцуулсан нийт 11,535.8 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоох

2.8.1.3 Урьдчилж гарсан зардал

БОАЖС-ын 2018 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн А/279 дугаар тушаалаар Ойжуулалт, ойн арга хэмжээний зардлаас гадаад орнуудад томилолтоор ажиллах 46,000.0 мянган төгрөг баталсанаас томилолтын хугацаа тодорхойгүй, Эйр эксперт

трэвел ХХК руу 34,896.9 мянган төгрөгийн тийзний төлбөрийг урьдчилан шилжүүлж авлагаар үүсгэсэн байна.

Энэ нь үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 6.6.6-д “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлсэн: Албан шаардлага хүргүүлэх

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

БОАЖЯ-ны ойжуулалт, ойн арга хэмжээ хөтөлбөрийн хүрээнд хийсэн худалдан авалт, тендер шалгаруулалт, ажлын гүйцэтгэл, үр дүнг дараагийн аудитаар авч үзэх.

Ойжуулалт, ойн арга хэмжээ хөтөлбөрийн гүйцэтгэлээс бусад анхаарал татах чухал асуудалгүй байна.

2.10 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Ойн судалгаа, хөгжлийн төвийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 32 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 212,436.9 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 192,079.4 мянган төгрөг буюу 90.4 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал болон цалингийн зардлын хэмнэлтээс шалтгаалжээ.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Ойн судалгаа, хөгжлийн төв Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 зөвлөмж, 3 албан шаардлага, 1 төлбөрийн актын биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Ойн судалгаа, хөгжлийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Ойн судалгаа, хөгжлийн төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Ойн судалгаа, хөгжлийн төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Анхан шатны баримтын бүрдэл

3.1.1 Илрүүлэлт

БОАЖС-ын 2018 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн А/279 дугаар тушаалаар Ойжуулалт, ойн арга хэмжээний зардлаас гадаад орнуудад томилолтоор ажиллах 46,000.0 мянган төгрөг баталсанаас Их Британи улсын Лондон хотод ажиллах 6 хоног 7 өдрийн томилолтын зардал 11,103.1 мянган төгрөгийг зарцуулсан боловч томилолтын удирдамжид заасны дагуу томилолтын тайлан, илтгэх хуудас бичээгүй, үр дүнг тайлагнаагүй, холбогдох анхан шатны баримтгүй байна.

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно гэж заасантай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл

Батлагдсан төсөв зориулалт бусаар зарцуулагдах

3.1.3 Өгсөн зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг баримталж ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,746,345,072.79	1,271,982,077.09
33	АВЛАГА	403,151,404.61	71,856,657.97
335	Бусад авлага	403,151,404.61	71,856,657.97
.13351	Байгууллагаас авах авлага	403,151,404.61	71,856,657.97
34	УРЬДЧИЛГАА	2,665,481,800.00	00.00
34600	Урьдчилж гарсан зардал	2,665,481,800.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	677,711,868.18	1,200,125,419.12
351	Түүхий эд материал	14,926,200.80	231,875,200.80
35110	Тусгай зориулалттай материал	14,926,200.80	231,875,200.80
35300	Бэлэн бүтээгдэхүүн	15,276,918.80	11,906,018.80
354	Хангамжийн материал	647,508,748.58	956,344,199.52
35410	Бичиг хэргийн материал	2,654,000.00	00.00
35420	Аж ахуйн материал	00.00	2,028,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	2,900,000.00
35470	Бусад хангамжийн материал	644,854,748.58	951,416,199.52
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	984,579,472.22	7,737,329,554.87
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	984,579,472.22	7,737,329,554.87
392	Биет хөрөнгө	984,432,472.22	1,565,056,888.21
39201	Барилга, байгууламж, орон сууц	257,733,446.40	182,105,640.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-160,038,777.91	-32,006,171.68
39203	Авто-тээврийн хэрэгсэл	790,205,481.38	1,477,614,481.38
39204	Хуримтлагдсан элэгдэл	-299,842,443.89	-436,577,144.39
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	659,893,216.81	745,655,207.71
39206	Хуримтлагдсан элэгдэл	-293,242,493.83	-403,714,235.33
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	40,858,329.33	43,783,729.33
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17,134,286.07	-20,787,018.81
39214	Бусад үндсэн хөрөнгө	29,937,223.00	10,282,400.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-23,937,223.00	-1,300,000.00
393	Биет бус хөрөнгө	147,000.00	6,172,272,666.66
39301	Програм хангамж	747,000.00	14,247,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-600,000.00	-1,580,333.34
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	6,159,606,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,730,924,545.01	9,009,311,631.96
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	323,188,956.00	920.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	323,188,956.00	920.00
413	Өглөг	323,188,956.00	920.00
4136	Бусад өглөг	323,188,956.00	920.00
41361	Байгууллагад төлөх өглөг	323,188,956.00	920.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,407,735,589.01	9,009,310,711.96
51	Засгийн газрын хувь оролцоо	4,407,735,589.01	9,009,310,711.96
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	536,870,268.14	6,696,476,268.14
51101	Өмч: - төрийн	536,870,268.14	6,696,476,268.14
512	Хуримтлагдсан үр дүн	3,870,865,320.87	2,241,860,527.63
51210	Өмнөх үеийн үр дүн	3,870,865,320.87	3,870,865,320.87
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-1,629,004,793.24
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	00.00	70,973,916.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,730,924,545.01	9,009,311,631.96

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	7,736,609,411.00	9,332,446,781.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,774,590.00	102,394,790.90
120	Нийтлэг татварын бус орлого	11,774,590.00	102,394,790.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,774,590.00	102,394,790.90
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,774,590.00	63,009,130.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	39,385,660.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,724,834,821.00	9,230,051,991.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	210,667,000.00	212,436,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	210,667,000.00	212,436,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,514,167,821.00	9,017,615,091.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	83,358,902.00	99,206,135.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,430,808,919.00	8,918,408,956.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,856,101,737.94	10,947,895,895.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,856,101,737.94	10,947,895,895.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,510,517,436.25	10,663,286,537.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	284,355,012.96	386,885,143.09
210101	Үндсэн цалин	225,881,529.96	347,182,779.09
210102	Нэмэгдэл	30,781,855.00	11,654,364.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,691,628.00	28,048,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,463,479.47	40,375,239.94
210201	Тэтгэврийн даатгал	19,444,166.01	29,615,080.94
210202	Тэтгэмжийн даатгал	2,715,263.69	2,715,651.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,215,240.35	2,172,546.00
210204	Ажилгүйдлийн даатгал	531,366.58	538,214.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,557,442.84	5,333,748.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,489,070.00	18,468,800.00
210301	Гэрэл, цахилгаан	5,295,600.00	2,600,000.00
210302	Түлш, халаалт	12,193,470.00	15,868,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,122,216.40	159,660,934.24
210401	Бичиг хэрэг	11,226,963.12	25,573,801.00
210402	Тээвэр, шатахуун	12,196,356.00	127,423,440.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,473,241.28	5,892,693.24
210404	Ном, хэвлэл	120,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,105,656.00	771,000.00
2105	Нормативт зардал	5,277,000.00	1,141,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,277,000.00	1,141,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,064,700.00	27,390,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,439,500.00	791,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,878,000.00	00.00
210604	Урсгал засвар	8,747,200.00	26,599,300.00
2107	Томилолт, зочны зардал	145,910,211.00	229,994,931.00
210701	Гадаад албан томилолт	4,787,000.00	78,286,330.00
210702	Дотоод албан томилолт	141,123,211.00	151,708,601.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,655,085,564.30	4,722,851,044.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,651,591,894.30	4,719,782,044.90

Ойн судалгаа хөгжлийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	1,485,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,701,770.00	792,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	633,500.00	633,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	320,750,182.12	5,076,518,644.46
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	147,501,458.11	4,791,116,701.06
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	200,000.00	27,689,829.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	173,048,724.01	257,712,114.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	345,584,301.69	284,609,357.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,600,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,600,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	341,984,301.69	284,609,357.47
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	341,984,301.69	284,609,357.47
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>2,880,507,673.06</u>	<u>-1,615,449,113.20</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	590,000.00	00.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	590,000.00	00.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,102,758.76	13,555,680.04
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,102,758.76	00.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	13,555,680.04
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)	-512,758.76	-13,555,680.04
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>2,879,994,914.30</u>	<u>-1,629,004,793.24</u>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>7,737,199,411.00</u>	<u>9,293,061,121.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,364,590.00	63,009,130.00
120	Нийтлэг татварын бус орлого	12,364,590.00	12,727,630.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,364,590.00	12,727,630.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,364,590.00	12,727,630.00
124	Зээлийн орлого	00.00	50,281,500.00
141001	Гадаадын санхүүгийн зээлийн эх үүсвэр	00.00	50,281,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,724,834,821.00	9,230,051,991.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	210,667,000.00	212,436,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	210,667,000.00	212,436,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,514,167,821.00	9,017,615,091.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	83,358,902.00	99,206,135.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,430,808,919.00	8,918,408,956.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>7,380,118,311.00</u>	<u>8,539,008,821.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,380,118,311.00	8,539,008,821.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,034,534,009.31	8,254,399,463.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	283,199,422.96	388,754,439.09
210101	Үндсэн цалин	216,541,274.96	317,009,029.09
210102	Нэмэгдэл	34,271,520.00	33,154,147.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,386,628.00	38,591,263.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,145,283.07	39,698,633.20
210201	Тэтгэврийн даатгал	21,125,969.62	28,362,838.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,691,123.69	2,797,769.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,215,240.34	2,238,241.00
210204	Ажилгүйдлийн даатгал	555,506.58	554,638.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,557,442.84	5,745,147.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,859,070.00	18,468,800.00
210301	Гэрэл, цахилгаан	5,452,800.00	2,600,000.00
210302	Түлш, халаалт	12,406,270.00	15,868,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,262,687.28	161,889,067.24
210401	Бичиг хэрэг	11,821,800.00	20,904,539.00
210402	Тээвэр, шатахуун	10,975,100.00	128,578,255.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,973,241.28	7,234,503.24
210404	Ном, хэвлэл	7,386,890.00	123,020.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,105,656.00	5,048,750.00
2105	Нормативт зардал	5,218,400.00	17,193,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,218,400.00	17,193,500.00

Ойн судалгаа хөгжлийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,292,100.00	50,476,110.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,416,900.00	18,461,000.00
210602	Тавилга	00.00	1,564,340.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,941,000.00	1,739,000.00
210604	Урсгал засвар	8,934,200.00	28,711,770.00
2107	Томилолт, зочны зардал	225,600,191.00	151,707,247.00
210701	Гадаад албан томилолт	79,908,250.00	00.00
210702	Дотоод албан томилолт	145,691,941.00	151,707,247.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,352,502,365.00	7,326,784,348.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,349,008,695.00	7,323,715,348.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	1,485,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,701,770.00	792,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	633,500.00	633,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	158,400.00	158,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,454,490.00	99,427,319.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,254,490.00	65,717,720.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	200,000.00	33,709,599.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	345,584,301.69	284,609,357.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,600,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,600,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	341,984,301.69	284,609,357.47
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	341,984,301.69	284,609,357.47
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>357,081,100.00</u>	<u>754,052,300.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	357,081,100.00	754,052,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	357,081,100.00	754,052,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	357,081,100.00	754,052,300.00
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	357,081,100.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	754,052,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-357,081,100.00</u>	<u>-754,052,300.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	536,870,268.14	00.00	990,870,406.56	00.00	1,527,740,674.70
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	536,870,268.14	00.00	990,870,406.56	00.00	1,527,740,674.70
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	2,879,994,914.30	00.00	2,879,994,914.30
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	536,870,268.14	00.00	3,870,865,320.87	00.00	4,407,735,589.01
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	536,870,268.14	00.00	3,870,865,320.87	00.00	4,407,735,589.01
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	536,870,268.14	00.00	3,870,865,320.87	00.00	4,407,735,589.01
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	70,973,916.19	00.00	00.00	70,973,916.19
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	6,159,606,000.00	00.00	-1,629,004,793.24	00.00	4,530,601,206.76
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,696,476,268.14	70,973,916.19	2,241,860,527.63	00.00	9,009,310,711.96

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	212,436,900.00	192,079,447.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	212,436,900.00	192,079,447.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	212,436,900.00	192,079,447.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	151,562,200.00	144,453,891.09
210101	Үндсэн цалин	99,763,900.00	103,781,442.09
210102	Нэмэгдэл	37,648,300.00	31,210,249.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,150,000.00	9,462,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,187,400.00	17,295,399.20
210201	Тэтгэврийн даатгал	12,124,900.00	11,810,226.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,515,600.00	1,321,705.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,212,500.00	1,057,391.00
210204	Ажилгүйдлийн даатгал	303,100.00	264,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,031,300.00	2,841,777.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,144,800.00	3,728,000.00
210301	Гэрэл, цахилгаан	5,139,100.00	00.00
210302	Түлш, халаалт	6,005,700.00	3,728,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,278,600.00	18,689,957.00
210401	Бичиг хэрэг	6,145,900.00	6,071,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,790,000.00	4,275,757.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,425,600.00	1,425,600.00
2105	Нормативт зардал	2,851,200.00	2,851,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,851,200.00	2,851,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,425,600.00	1,420,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,425,600.00	1,420,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,433,100.00	00.00
210702	Дотоод албан томилолт	3,433,100.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	3,069,000.00	3,069,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,485,000.00	1,485,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	792,000.00	792,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	633,600.00	633,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	158,400.00	158,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,485,000.00	572,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,485,000.00	572,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	0.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	212,436,900.00	212,436,900.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	212,436,900.00	212,436,900.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	212,436,900.00	212,436,900.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	0.00
14	БУСАД ЭХ ҮҮСВЭР	00.00	0.00

Ойн судалгаа хөгжлийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

145005	Бусад орлого	00.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	00.00	00.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	00.00	00.00
610001	Төсвийн байгууллага	00.00	00.00
610002	Төсвөөс гадуур байгууллага	00.00	00.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	12	12
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	11	11

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан / төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		9,069,187,221.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		9,069,187,221.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		8,811,322,316.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		244,300,548.00
210101	Үндсэн цалин		213,227,587.00
210102	Нэмэгдэл		1,943,898.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		29,129,063.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		22,403,234.00
210201	Тэтгэврийн даатгал		16,552,612.00
210202	Тэтгэмжийн даатгал		1,476,064.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		1,180,850.00
210204	Ажилгүйдлийн даатгал		290,338.00
210205	Эрүүл мэндийн даатгал		2,903,370.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		14,740,800.00
210301	Гэрэл, цахилгаан		2,600,000.00
210302	Түлш, халаалт		12,140,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал		141,199,110.24
210401	Бичиг хэрэг		12,833,039.00
210402	Тээвэр, шатахуун		121,661,155.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		2,958,746.24
210404	Ном, хэвлэл		123,020.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		3,623,150.00
2105	Нормативт зардал		14,342,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		14,342,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		61,635,510.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		28,461,000.00
210602	Тавилга		4,143,740.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		319,000.00
210604	Урсгал засвар		28,711,770.00
2107	Томилолт, зочны зардал		151,707,247.00
210702	Дотоод албан томилолт		151,707,247.00

Ойн судалгаа хөгжлийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		8,061,342,248.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		8,061,342,248.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		99,651,319.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		65,941,720.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		33,709,599.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		257,864,904.76
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		257,864,904.76
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		257,864,904.76
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		9,069,187,221.00
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		7,034,630.00
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		7,034,630.00
	Бусад эх үүсвэр		44,537,500.00
	Бусад орлого		44,537,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		9,017,615,091.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		99,206,135.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		8,918,408,956.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

5 ХАВСРАЛТ

5.1 Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

Огноо: 2019/02/22	Аудитын нэр:	<i>Ойн судалгаа хөгжлийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудит</i>	Аудитын код: САГ-2019/368/ СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Ойн судалгаа хөгжлийн төв		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
А	3	4	5			9	10
1	Ойжуулалт, ойн арга хэмжээний гэрээт ажлыг гүйцэтгээгүй 2 аж ахуйн нэгжид олгосон санхүүжилт	39,351.2	Төлбөрийн акт			Захирал Нягтлан бодогч	Д.Мөнхбат Д.ганчимэг
2	Өмнөх оны авлага 2,400.0 мянган төгрөг, гэрээт ажлын үлдэгдэл санхүүжилт 9,135.8 мянган төгрөг нийт 11,535.8 мянган төгрөгийг давхардуулан шилжүүлсэн байна.	11,535.8	Төлбөрийн акт			Захирал Нягтлан бодогч	Д.Мөнхбат Д.ганчимэг
3	БОАЖС-ын 2018 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн А/279 дугаар тушаалаар Ойжуулалт, ойн арга хэмжээний зардлаас гадаад орнуудад томилолтоор ажиллах 46,000.0 мянган төгрөг баталсанаас томилолтын хугацаа тодорхойгүй, Эйр эксперт трэвел ХХК руу 34,896.9 мянган төгрөгийн тийзний төлбөрийг урьдчилан шилжүүлж авлагаар үүсгэсэн байна.	34,896.9	Албан шаардлага			Захирал Нягтлан бодогч	Д.Мөнхбат Д.ганчимэг
4	Гадаад томилолтын удирдамжид заасны дагуу томилолтын тайлан, илтгэх хуудас бичээгүй, үр дүнг тайлагнаагүй, холбогдох анхан шатны баримтгүй бүрдүүлээгүй байна.	11,103.1	Зөвлөмж			Захирал Нягтлан бодогч	Д.Мөнхбат Д.ганчимэг
Нийт		96,887.0					

